

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН
2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 09-15-НЫ
ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2022 оны 09 дүгээр сарын 29

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: 705631111 утсанд Хэрлэн 1-р сургуулийн хойд талд маш их хог хуралддаг, хүүхдүүд хог ихтэй газраар явж байна, Нисэхийн 28-р эгнээнд хог их байна, А-61-р байранд халуун ус өгөхгүй байна, мал ихтэй айл өрхийг төвөөс зайдуу байршуулах хэрэгтэй байна гэсэн утга бүхий өргөдлүүд ирснийг холбогдох байгууллагад шилжүүлэн хариу өгсөн 2, шийдвэрлэлтийн шатандаа 3 байна.

Засгийн газрын 1111 төвөөр Хэнтий аймгийн Баянмөнх сумын Гангантөгс нь СӨБ -д шууд эрхлэгчээр ажилласан. Хүний нөөцөө бүрдүүлэхдээ дандаа ашиг сонирхлын үүднээс ханддаг. Малтай хүнийг ажилд авч мах авдаг. Цэцэрлэгийн хүүхдүүддээ өдөрт 3 аягаас илүү ус өгдөггүй, цэвэрлэгээний бодис пэйри хэрэглээд цэвэр усаар аягаа зайлдаггүй учраас хүүхдийн аяганаас байнга пэйри үнэртэж амтагддаг. Аймгийн СӨБ хариуцсан мэргэжилтэн Мөнгөнбаярт гомдол гаргахаар шалгахгүйгээр шууд Гангантөгсд тэр хүн ингэж гомдол гаргаж байна гээд хэлчихдэг. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, шалгаж өгнө үү.гэсэн өргөдөл ирснийг удирдлагад танилцуулагдан НБХэлтэст цохогдон судлагдаж байна.

Хэнтийн аймгийн Норовлин суманд шилжиж очиж байна. Хэнтий аймгийн сумын засаг дарга зөвшөөрсөн байхад нутгийн иргэд зөвшөөрөхгүй байна. Багийн хурлаар орох шаардлагатай байна. Тэр багийн айлуудаас зөвшөөрөл ав гээд тулган шаардаад байна. Миний гомдлыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.гэсэн өргөдлийг удирдлагад танилцуулагдан шийдвэрлэлтийн шатандаа судлагдаж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийт 348 иргэн үйлчлүүлж Утсаар 11, цахимар 30, өөртөө үйлчлэх танхимаар 126, Үүнээс биечлэн 181 иргэн үйлчлүүлснээс. Улсын бүртгэлээр 85, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 24, Татварын үйлчилгээгээр 9, Нотариатаар 7, Хууль зүйн зөвлөгөөгөөр 2 иргэнд зөвлөгөө өгсөн. Төрийн банкаар 35, e-mongolia сурталчилах цэгээр 6, E-khutuch.mn булангаар 5, /цахим дэлгэцээр 8 / иргэн үйлчлүүлсэн.

Нийгмийн даатгалын байцаагч ээлжийн амралттай, Газрын даамал Хэрлэн сум руу шилжин ажиллаж байгаа тул Нэгдсэн төвд ажиллаагүй. Өндөрхаан брокер диллер хариуцсан ажилтан цалин мөнгө өгдөггүй учир ажиллахгүй байгаа.

Үнэлгээний төхөөрөмжинд 181 үнэлгээ өгөгдсөнөөс: Маш сайн 177, сайн 1, дунд 3, байна.